



БАЯНХОНГОР АЙМАГ  
БААЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 12 өдөр

Дугаар А/193

Баянсайр

Г Цэргийн жинхэнэ албаны нэгдүгээр  
ээлжийн цэрэг татлагын ажлыг зохион  
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Цэргийн албаны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2, 12.3, 12.5, 13 дугаар зүйлийн 13.6, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.17, Засгийн газрын 2021 оны мн/132 дугаар тогтоол, Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын 2022 оны "Цэргийн жинхэнэ албаны халалт, татлагын ажлыг зохион байгуулах тухай" н/67 дугаар тушаал, аймгийн Засаг даргын 2022 оны 04 дүгээр сарын 04-ны өдрийн "Баянхонгор аймгийн 2022 оны нэгдүгээр ээлжийн цэргийн жинхэнэ албаны цэрэг халалт, таталтын ажлыг зохион байгуулах тухай" А/193 дугаар захирамжийн 8 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Сумын 2022 оны нэгдүгээр ээлжийн цэрэг татлагаар цэргийн жинхэнэ албанд 18-25 насны иргэдийг татах ажлыг 04 дүгээр сарын 28-ны өдөр зохион байгуулсугай.

2. Цэргийн жинхэнэ албаны татлагыг удирдан зохион байгуулж ажиллах, сумын цэрэг татлагын товчооны бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

3. Цэргийн жинхэнэ албанд татагдах 18-25 насны залуучуудад цэргийн албаны зарлан дуудах мэдэгдлийг биечлэн хүргэж, тооцоог тасалбараар хийхийг багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Цэргийн жинхэнэ албанд татагсдад эрүүл мэндийн урьдчилсан үзлэг, шинжилгээнд 04 дүгээр сарын 20-22-ны өдрүүдэд хамруулан серологи, иммунологи, цус, шээс, биохимийн шинжилгээ болон дүрс оношлогоо хийх, шаардлагатай сорил, эм, урвалж, эмнэлгийн тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангаж, эрүүл мэндийн үйлчилгээ шуурхай үзүүлж ажиллахыг Эрүүл мэндийн төвийн дарга /Д.Болормаа/-д даалгасугай.

• 642101349

5.Коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлж, цэрэг татлагын байранд ариутгал халдваргүйтгэл хийх, байранд зөвхөн захирамжаар томилогдсон цэрэг татлагын товчооны бүрэлдэхүүн, цэргийн насны залуучуудыг амны хаалттай, халууныг үзэж, гарыг ариутган оруулах зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Эрүүл мэндийн төвийн дарга /Д.Болормаа/-д даалгасугай.

6.Коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлж, цэрэг татлагын байрны орчим ар гэрийнхэн болон гадны иргэдийг олноор цуглуулж бөөгнөрөл үүсгэхгүй байх, цэрэг татлагын үед нийгмийн хэв журам сахиулах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, согтууруулах ундаа худалдаалахыг түр хугацаагаар хязгаарлаж, цэрэгт татагчдыг тээвэрлэх автомашины техникийн бүрэн бүтэн байдлыг хангуулж зөвшөөрөл өгөх, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авч ажиллахыг Цагдаагийн хэсгийн төлөөлөгч, цагдаагийн дэслэгч (Б.Өсөхбаяр) хэв журмын цагдаа, цагдаагийн дэд ахлагч (Э.Балжинням), нарт даалгасугай.

7. Цэрэг татлагын товчооны нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт ороогүй цэргийн үүрэгтний шалтгааныг тодотгон хүн тус бүрээр тооцоог гаргаж, аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабтай хийхийг сумын цэрэг татлагын товчоо /Б.Наранбаатар/-т даалгасугай.

8. Цэрэг татлагын зардалд шаардагдах хөрөнгийг сумын Засаг даргын Тамгын газрын холбогдох зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газрын төсвийн шууд захирагч /Б.Наранбаатар/-т зөвшөөрсүгэй.


9. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын орлогч (Б.Бямбаням)-д үүрэг болгосугай.

ДАРГА С.ЭНХТӨР

A handwritten signature in black ink is written over a red rectangular official stamp. The stamp contains Mongolian text, including the name 'С.ЭНХТӨР' (S. ENKHTOR) and the title 'ДАРГА' (DARGA). The signature is a cursive script that overlaps the stamp.

Сумын Засаг даргын ..... оны  
.....дүгээр сарын .....ныгөдрийн .....  
дугаар захирамжийн хавсралт

ЦЭРЭГ ТАТЛАГЫН ТОВЧООНЫ  
БҮРЭЛДЭХҮҮН



Дарга: Б.Наранбаатар –Засаг даргын Тамгын газрын дарга

Орлогч дарга: Э.Бат-Эрдэнэ – Байгаль орчны хяналтын Улсын байцаагч  
Нарийн бичгийн

дарга: Г.Энхжаргал- Хууль эрх зүйн мэргэжилтэн

Гишүүдэд: Д.Болормаа - Эрүүл мэндийн төвийн дарга

Б.Өсөхбаяр –Хэсгийн төлөөлөгч, цагдаагийн дэслэгч

Л.Дашмаа -Нийгмийн даатгалын байцаагч

О.Дашдаваа – Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн

Ө.Лхагвасүрэн –Насан туршийн боловсролын арга зүйч

Э.Балжинням –Хэв журмын цагдаа, дэд ахлагч

П.Ичинхорлоо –Эрүүл мэндийн лаборант

П.Батгэрэл -1 дүгээр багийн Засаг дарга

Т.Билэггэндэн – 2 дугаар багийн Засаг дарга

Ж.Солонго -3 дугаар багийн Засаг дарга

П.Мөнхжаргал -4 дүгээр багийн Засаг дарга

Д.Баттөр -5 дугаар багийн Засаг дарга

Г.Баянжаргал-6 дугаар багийн Засаг дарга

Б.Хүрэлбаатар /7 дугаар багийн Засаг дарга/

Б.Байгальмаа- 1 дүгээр багийн эмч

Н.Цэцгээ-2 дугаар багийн эмч

П.Сугарсүрэн-3 дугаар багийн эмч

Д.Хоролдулам – 5 дугаар багийн эмч

П.Дулам - 6 дугаар багийн эмч

Т.Батсүх –Тамгын газрын нярав